

ODO SHOP АППЛИКЕЙШНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

ODO SHOP аппликейшн (цаашид “апп” гэх) нь “ОДО ШОП АПП” ХХК-ийн зохиосон Odo цахим худалдааны платформын гар утасны апп (цаашид Odo платформ, Odo shop аппыг хамтад нь “уг програм” гэх) юм.

Энэхүү үйлчилгээний нөхцөл нь цахим орчинд бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авахтай холбоотой үүсэж буй харилцааг зохицуулна.

Энэхүү Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1. “Хэрэглэгч” гэж энэхүү Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, “ODO SHOP” аппыг хэрэглэж буй иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн
2. “Худалдаа эрхлэгч” гэж Бараа бүтээгдэхүүн борлуулах болон үйлчилгээ үзүүлэх албан ёсны эрхтэй хуулийн этгээд, хувь хүнийг

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Хэрэглэгч нь “ODO SHOP” -д нэвтэрсэн, бүртгүүлсэн үеэс эхлэн Үйлчилгээний нөхцөлийг мөрдөх бөгөөд тухайн үеэс уг нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
2. Хэрэглэгч нь уг програмын үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсны үндсэн дээр уг програмаар бараа бүтээгдэхүүн захиалах, хүслийн жагсаалт үүсгэх, өөрийн захиалгыг хянах эрхтэй болно.
3. Уг програм нь зөвхөн худалдаа эрхлэгч, хэрэглэгч хоёрыг холбох үүрэгтэй дундын зуучлагч системийн үйлчилгээг үзүүлнэ.
4. Энэхүү үйлчилгээний нөхцөлийн хэрэгжилтэд хэрэглэгч болон хөгжүүлэгч хамтран хяналт тавина.
5. Уг програмыг зөвхөн насанд хүрэгчид ашиглах ба насанд хүрээгүй хүүхэд бие даан ашиглахыг хориглоно. Насанд хүрээгүй хүүхэд зөвхөн эцэг эхийн хамт үйлчилгээний нөхцөлийн дагуу ашиглах боломжтой.
6. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу согтууруулах төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглосон өдөр тухайн бараа бүтээгдэхүүнийг захиалах, худалдан авах, худалдаа эрхлэгчээс худалдаалахыг шаардах зэрэг хэрэглэгч ямар нэгэн хэлбэрээр хууль зөрчин ашигласан тохиолдолд хөгжүүлэгч хариуцлага хүлээхгүй.
7. Уг програмын мэдээллийн нууцлал, хэвийн ажиллагаанд хөгжүүлэгчийн боломж, чадвараас давсан нөхцөл байдлын улмаас үүссэн аливаа асуудалд хөгжүүлэгч хариуцлага хүлээхгүй боловч аюулгүй байдал, тасалдалгүй ажиллагаа, хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг орчин үеийн технологи ашиглан хөгжүүлэлтийн боломжит дээд түвшинд хамгаалан ажиллана.
8. Хөгжүүлэгч хэрэглэгчийн мэдээллийг сервер ба хэрэглэгчийн төхөөрөмжид зохих түвшинд хамгаалан хадгалах, дамжуулах ба хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй. Үүнд: Монгол улсын хуулийн дагуу хуулийн байгууллагын шаардлагаар дамжуулах тохиолдол хамаарахгүй.

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, АНХААРАХ ЗҮЙЛС

1. Хэрэглэгч нь уг програмыг Монгол улсын хууль, холбогдох дүрэм, журмын хүрээнд ашиглана.
2. Хэрэглэгч уг програмын лого, нэр, загвар, зураг, текстийг хуулах, олшруулах, дуурайх, өөр бусад ямар ч хэлбэрээр ашиглахыг хориглоно.
3. Хэрэглэгч нь уг програмд байрласан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зураг, текст зэрэг бусдын оюуны өмчийг хууль бусаар ашиглахыг хориглоно.
4. Хэрэглэгч нь уг програмд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх, үүнтэй холбоотой учирч болох аливаа эрсдэлээс сэргийлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсний улмаас өөрт болон бусдад учирсан аливаа хохирлыг хөгжүүлэгч хариуцахгүй.
5. Хэрэглэгч нь уг програмд бүртгүүлсэн, оруулсан бүх мэдээллийнхээ үнэн зөв, бодит байдалд бүрэн хариуцлага хүлээнэ.
6. Хэрэглэгч уг програмын талаар санал гомдол, шинэ санаа, өөрийн дэлгүүрийг бүртгүүлэх хүсэлт, шүүмж зэргийг чөлөөтэй илэрхийлэх, илгээх эрхтэй.
7. Хэрэглэгч нь хаяг болон байршлын мэдээллийг дэлгэрэнгүй, тодорхой, зөв оруулах үүрэгтэй ба өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүрт шинэчлэх үүрэгтэй. Тодорхой бус, буруу, алдаатай, хуучирсан хаягийн мэдээллээс болж хүргэлт саатах, хоцрох тохиолдолд Хөгжүүлэгч болон Худалдаа эрхлэгч хариуцлага хүлээхгүй. Хаяг тодорхой бус байдлаас үүдэн ямар нэгэн маргаантай асуудал үүссэн тохиолдолд Худалдаа эрхлэгч болон Хэрэглэгчид хоорондоо асуудлаа шийдвэрлэнэ. Тухайн хэрэглэгчийн оруулсан хаяг буруу, алдаатай, хуучирсан хаягаас үүдсэн асуудлын хариуцлагыг хэрэглэгч өөрөө хүлээнэ.
8. Хэрэглэгч худалдан авсан бараа бүтээгдэхүүнээ захиалга өгөхдөө оруулсан хаягаар хүргүүлэх боломжтой.
9. Уг програм руу мэдээлэл хулгайлах, будлиулах, залилах, хакердах, гэмт хэргийн зорилгоор халдах ба халдах оролдлого хийхийг хориглоно.

ГУРАВ. ЗАХИАЛГА ХИЙХ, БАТАЛГААЖИХ

1. Хэрэглэгч 24 цагийн аль ч цагт хэдэн ч удаа захиалга хийж болно.
2. Хэрэглэгч нь өөрийн сонгосон бараа бүтээгдэхүүнийг сагсанд хийж, цааш үргэлжлүүлэн захиалах товч дарж байж захиалга эцэслэнэ. Хэрэв хэрэглэгч бараа бүтээгдэхүүнээ зөвхөн сонгож сагсанд хийгээд орхих зэрэг захиалгаа дутуу хийсэн тохиолдолд дэлгүүр, худалдаа эрхлэгчид захиалга хүрэхгүйг анхаарна уу!
3. Захиалгын төлөв
 - i. Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг сонгон, хүргүүлэх хаягаа оруулж, тухайн захиалга уг програмаар дэлгүүрт илгээгдсэнээр захиалга үүсэж ИЛГЭЭСЭН төлөвтэй болно.
 - ii. Худалдаа эрхлэгч тухайн захиалгыг хүлээн авч хэрэглэгч рүү хүргэлт хийхээр зөвшөөрсөн тохиолдолд БАТАЛГААЖСАН гэсэн төлөвт шилжинэ.

- iii. Хэрэглэгч захиалсан бараа бүтээгдэхүүнийг өөрийн гар дээр амжилттай хүлээн авсан бол ХҮЛЭЭН АВСАН төлөвт шилжүүлнэ.
 - iv. Хэрэв худалдаа эрхлэгч захиалсан бараа бүтээгдэхүүнийг хүргэх боломжгүй бол захиалгыг цуцалж төлөвийг ЦУЦЛАГДСАН болгон өөрчилж болно.
4. Хүргэлтийн хугацаа
- i. Худалдаа эрхлэгч өөрийн борлуулалт, түгээлтийн нөхцөлийн дагуу хэрэглэгчид хүргэнэ. Хэрэглэгчийн сонгосон дэлгүүр, хүргэх хаягийн зайнаас хүргэлтийн хугацаа хамаарна.
 - ii. Хэрэв хэрэглэгч захиалга хүлээн авах цагаа сонгосон бол худалдаа эрхлэгч нь тэр цагт хүргэх ба тухайн захиалсан цагаас хоцорсон тохиолдолд тухайн дэлгүүрийн мэдээллээс утасны дугаарыг авч холбогдон шаардаж, гомдлыг барагдуулна.
 - iii. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоосон, гамшгийн нөхцөл байдал үүссэн болон бусад хүчин зүйлийн улмаас худалдаа эрхлэгч нь таны захиалгыг хүлээн авах, хүргэлт хийхэд саатал үүсэж болно.
 - iv. Давагдашгүй нөхцөл байдлаас үүссэн аливаа асуудлыг хэрэглэгч болон худалдаа эрхлэгчид харилцан ойлголцож эвийн журмаар шийдвэрлэнэ.
5. Хэрэглэгч захиалга хийхдээ уг програмд байгаа бараа бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга, мэдээллийг сайтар судлах шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд хэрэглэгч тус бараа бүтээгдэхүүний талаар худалдаа эрхлэгч дэлгүүртэй холбогдон тодруулсны үндсэн дээр захиалга, худалдан авалт хийх нь зүйтэй. Захиалга хүргэгдэн ирсний дараа захиалгыг буцаах хүсэлтийг систем хүлээн авах, бараа бүтээгдэхүүнийг буцаах боломжгүй.
6. Худалдаа эрхлэгчийн оруулсан мэдээллийн дагуу тухайн дэлгүүрийн ажиллах цагийн хуваарь, хүргэлтийн хуваарь зэрэг нь өөр, өөр байж болно.
7. Худалдаа эрхлэгч нь бараа бүтээгдэхүүний талаарх мэдээлэл, үнэ, үлдэгдэл зэргийг хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчилж болно.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТӨЛӨХ

1. Хэрэглэгчийн хийсэн захиалга бүр дахин давтагдашгүй захиалгын дугаартай байх бөгөөд “Захиалгын түүх” хэсгээс захиалгын дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.
2. Худалдаа эрхлэгчийн оруулсан төлбөрийн нөхцөлийн дагуу захиалсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг бэлэн болон цахим төлбөрийн хэлбэрээс сонгон хийнэ.
3. Уг програм нь хэрэглэгч бараа бүтээгдэхүүн захиалах, худалдан авах, худалдаа эрхлэгчийн зарласан аливаа хямдрал урамшуулалд хамрагдах гэх мэт апп ашиглахад үнэ төлбөргүй байна.
4. Хэрэглэгч бараа бүтээгдэхүүний мэдээлэлтэй сайтар танилцан, унших шаардлагатай бөгөөд захиалгаа давхар нягтлах үүрэгтэй. Хэрэглэгч тус бараа бүтээгдэхүүний талаар сайтар мэдээлэл аваагүйн улмаас үүсэх аливаа асуудал мөн захиалгын төлбөрийг урьдчилан төлсөн бол тухайн бараа бүтээгдэхүүнийг буцаах, захиалгыг цуцлах боломжгүй бөгөөд үүссэн нөхцөл байдалд хөгжүүлэгч хариуцлага хүлээхгүй.

ТАВ. ОЮУНЫ ӨМЧТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

1. Уг програмын доторх тэмдэгт лого зэрэг нь “ОДО ШОП АПП” ХХК-ийн өмч юм.
2. Уг програмд байрласан бүтээгдэхүүний зураг лого зэрэг нь тухайн бүтээгдэхүүний оюуны өмчийн эзэмшигчийн өмч болно.
3. Оюуны өмчийн эрх зөрчигдсөн тохиолдолд холбогдох этгээдэд Оюуны өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. БУСАД

1. Энэхүү үйлчилгээний нөхцөлийн заалтууд нь өөрчлөгдөх боломжтой. Хэрэв уг програмын үйлчилгээний нөхцөл өөрчлөгдөх, шинэчлэгдэх тохиолдолд тухай бүрт <https://shop.odo.mn/> цахим хаягт нийтлэх бөгөөд Хэрэглэгч нь танилцах үүрэг хүлээнэ.
2. Хэрэглэгчийг захиалга хийх үед хүчинтэй байсан үйлчилгээний нөхцөл нь захиалга хүлээж авах хүртэлх хугацаанд өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх үйлчилгээний нөхцөлийг бараа бүтээгдэхүүн хүлээж авах хүртэлх хугацаанд хүчинтэйд тооцно.
3. Энэхүү үйлчилгээний нөхцөлтэй цахим хэлбэрээр уншиж танилцан бүртгүүлж ашигласнаар цаасан дээр байгуулсан гэрээнд гарын үсэг зурж зөвшөөрсний нэгэн адил хүчин төгөлдөр гэрээтэй дүйцүүлж тооцно.